



ШИХИХУТУГ ИХ СУРГУУЛЬ ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улс

Улаанбаатар хот

2018 он

АГУУЛГА

1. 2018-2026 ОН ХҮРТЭЛХ ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО
2. ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ШАЛГУУРУУД
3. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ
4. ХАВСРАЛТ¹

¹ СДИО стандартуудыг хавсралт №1-ээс үзнэ үү.

2018-2026 ОН ХҮРТЭЛХ ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ТЕХНОЛОГИЙГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛНЭ.

**ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН МАРКЕТИНГ, МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОНО.**

**ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧДЫГ ИДЭВХИЖҮҮЛЭХ ЦОГЦ БОДЛОГО
ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

**ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ОЛОН ХУВИЛБАРТ
ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОНО**

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ШАЛГУУРУУД

ЗОРИЛГО НЭГ.

ХӨТӨЛБӨРИЙН ТЕХНОЛОГИЙГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛНЭ.²

№	ЗОРИЛТУУД	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.	Зорилт №1 Олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэж сургалтын төлөвлөгөөг олон улсын жишигт нийцүүлэн уян хатан хувилбарт шилжүүлэх	<ul style="list-style-type: none"> Сургалтын төлөвлөгөөнд заавал судлах, сонгон судлах хичээлүүдийн олон улсын стандартыг нэвтрүүлэх CDIO суралцахуйн үр дүнгүүдийн хамаарлыг турших³ Хичээлийн агуулгыг кредит системд шилжүүлэх OXFORD EAP- арга зүйд суурилсан Англи хэлний стандартийг бүрэн нэвтрүүлэх 	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэх <p>CDIO 12 стандартыг бүрэн хэрэгжүүлэх / Хавсралт №1 /</p>
2.	Зорилт №2 Хөтөлбөрийн үнэлгээний тогтолцоо, шалгалтын технологийг шинэчлэх	<ul style="list-style-type: none"> Үнэлгээ, шалгалтын системийг хуульчийн мэргэжлийн шалгалтын агуулгад нийцүүлэх 	Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ

² Шихихутуг их сургуулийн хөгжлийн ерөнхий зураглалын дараах зорилтуудтай нийцүүлэн төлөвлөв.

Сургуулийн хөгжлийн шинэ шатны эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх зорилтууд:

- Оюутанд сонгон суралцах эрхээ эдлэх нөхцлийг бүрдүүлэх, судалгаа шинжилгээний арга зүй эзэмшүүлэх чиглэлээр сургалт, судалгааны **стандартын шинэчлэл** хийнэ. Багш, судлаач нарт сургалт, судалгааны шинэ бодлого (outcome based), арга технологи (CDIO)-г эзэмшүүлнэ.
- 2016-2018 онд бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлийг сургалт, судалгааны их сургууль болох зорилтод нийцүүлэн шинэчилнэ.
- Сургалт, судалгааны үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлж, сургалтын “E”орчинтой орчин үеийн дэд бүтэц бүхий **цахим сургууль** болно.

³ CDIO сургалтын 12 стандартын 1-3 дахь стандартын хүрээнд боловсруулан хэрэгжүүлэх агуулгаар төлөвлөсөн болно.

Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам. CDIO Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж.,УБ, 2007.,23 дахь тал

		<ul style="list-style-type: none"> Сургалтыг үр дүнд суурилсан арга технологигоор үнэлэх⁴ /CDIO / 	
3.	Зорилт №3 Орчин үеийн боловсролын салбарт нэвтэрч буй шинэ техник технологийг нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> Online-сургалтын технологийг нэвтрүүлэх Цахим орчинд суурилсан сургуулийн орчинг бүрдүүлэх. Үүний хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна. <ol style="list-style-type: none"> Зайн сургалтийн хөтөлбөр боловсруулах Програм хангамжийн шинэчлэл E-Book санг эрчимжүүлэх Интернет, техник хангамжийн шинэчлэл CLOUD UNIMIS системийг хэрэглэхэд хялбар APP-хэлбэрээр хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Сургалтын үр дүн сайжирна. Тус сургуульд элсэгчдийн тоо, чанар нэмэгдэнэ
4.	Зорилт № 4 Хөтөлбөрийн чанарын баталгааг хангах	<ul style="list-style-type: none"> Оюутны CDIO чадварыг хөгжүүлэх, бие даах, харилцан бие биенээсээ суралцах ёургалтын орчин бүрдүүлэх /CDIO стандартын 4-6 / Олон талт сургалтын арга, туршлагыг үе шаттайгаар нэвтрүүлэх /CDIO стандарт 7/ 	Хөтөлбөрийн чанарын түвшин нэмэгдэнэ, элсэгчид тавигдах шалгуур өснө.

⁴ CDIO сургалтын 12 стандартын 11 болон 12 дахь стандартын хүрээнд боловсруулан хэрэгжүүлэх агуулгаар төлөвлөсөн болно. Мөн дээрх бүтээлд

ЗОРИЛГО ХОЁР.

ХӨТӨЛБӨРИЙН МАРКЕТИНГ, МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО.⁵

№	ЗОРИЛТУУД	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.	Зорилт № 1 Хөтөлбөрийн менежментийн шинэчлэл хийх	<ul style="list-style-type: none"> • Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг идэвхижүүлэх • Management by value /MBV/ загварын хөтөлбөрийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэнэ. Үүний хүрээнд: <ol style="list-style-type: none"> 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх, сайжруулах 2. Хөтөлбөрийг хөгжүүлэхэд урамшууллын тогтолцоог бүрдүүлэх 3. Хөтөлбөрийн үнэт зүйлийн судалгааг 	Олон улсын болон үндэсний дээд боловсролын шилдэг менежмент, арга технологи эзэмшсэн, хууль эрх зүй, нийгмийн ухааны сургалт, судалгааны тэргүүлэх их сургууль байх гэх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд ⁶ .

⁵ Шихихутуг их сургуулийн хөгжлийн ерөнхий зураглалын 5 дахь зорилтын үзэл баримтлалд нийцүүлэн төлөвлөв.

2.5.4. Сургуулийг сурталчлах ажлын удирдлага, зохион байгуулалт, арга хэлбэрийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулах, цахим орчныг өргөнөөр ашиглах, сургуулийн сурталчилгааны ном товхимол, сонин зэргийн чанар, хүртээмжийг сайжруулах зэргээр шинэчилнэ.

2.5.5. Иргэдийн дунд хуулийн сурталчилгаа зохион байгуулах, эрх зүйн зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх, хууль тогтоомжийн төсөл хөтөлбөр боловсруулахад оролцох, санаачлах зэрэг сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээний чанар, цар хүрээг өргөтгөнө.

2.5.6. Сургууль Монгол Улсын их, дээд сургуулийн консорциум, Хуульчдын холбоо, Хувийн их, дээд сургуулиудын холбоо, ажил олгогч эздийн холбоо, худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг иргэний нийгмийн институтуудын үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцоно.

2.5.7. Төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудтай түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөх, тэдэнд гэрээ хэлцлийн үндсэн дээр эрх зүйн зөвлөгөө үзүүлэх, сургалт, судалгаа хийх зэргээр орлогын нэмэлт үүсвэр олох, бүрдүүлэхийг зорьж ажиллана.

⁶ Шихихутуг их сургуулийн хөгжлийн ерөнхий зураглалын 1 дүгээр бүлэг 1.2 дахь хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

		төлөвлөгөөний дагуу хийж, дүгнэх	
2.	Зорилт № 2 Хөтөлбөрийн маркетингийн шинэчлэл хийх ⁷	<ul style="list-style-type: none"> • Видео маркетинг.⁸ Ялангуяа богино видео контентоор маркетинг хийх • Шууд нэвтрүүлэг. Фэйсбүүкт өөрийн хөтөлбөрийн онцлогийн талаар Live-ийг хэрэглээг болгох • Чатбот хөгжүүлэх • LinkedIn дээр видео контент ашиглаж хөтөлбөрийн сурталчилгааг бий болгох • Нөлөөлөгчийн маркетинг төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх • Хөтөлбөрийн маркетингийн төсвийн төлөвлөгөөг жил бүрээр гаргаж, нэмэгдүүлэх бодлого баримтлах • Brand Book- ийн шинэчлэл тогтмол хийх 	Сургуулийн хөгжлийн шинэ шатны эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх 6 дугаар зорилтыг хангах

⁷ Хөтөлбөрийн маркетингийн шинэчлэл дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно.

1. Бүтээгдэхүүн –“төгсөгчид”

2. Хуваарилалт –“төгсөгчдөө цааш үргэлжлүүлэн суралцуулах”

3. Маркетингийн идэвхжүүлэлт

4. Үнэ – “сургалтын төлбөр, санхүүжилт”

5. Үйлчилгээний ажилтан –“ажилчид”

6. Процесс буюу үйл явц –“сургалтын үйл явц”

7. Орчин ба үйлчлүүлэгчид чиглэсэн үйлчилгээ –“сургалтын орчин “гэсэн иж бүрдэлтэй байна.

⁸ HubSpot академийн судлаачид видео маркетингийн өнөөгийн нөхцөл байдлыг судлан ирэх жилийн хандлагыг тооцоолон гаргадаг. Судалгаанд оролцсон хүмүүсийн 81% нь видеог маркетингийн арга хэрэгслээр сонгон ашиглаж байгаа ба 2018 онд энэ үзүүлэлт нь 61% байсан. Судалгаанд оролцогчдын 99% нь “видеог маркетингтаа аль хэдийн ашиглаад эхэлчихсэн. Цаашдаа ч үргэлжлүүлэн ашигласаар байх болно” гэж хариулсан. Видеог маркетингтаа ашигладаггүй гэж хариулсан хүмүүсийн 65% нь 2019 ондоо ашиглаж үзэх төлөвлөгөөтэй байна гэж хариулсан байна..

3.	Зорилт № 3 Хөтөлбөрийн эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх	<ul style="list-style-type: none"> • CDIO тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгүүдийн өөрчлөлтийг хийх • Дотоодын хууль тогтоомжийн шинэчлэл, бусад орны хөтөлбөрийн эрх зүйн орчны судалгааг тогтмол хийж, өөрчлөлт оруулах ECO RECAPTION хийх 	Хөтөлбөр хөгжүүлэх Эрх зүйн орчны шинэтгэл тогтмол хийгдэх
----	--	---	---

ЗОРИЛГО ГУРАВ.

ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧДЫГ ИДЭВХИЖҮҮЛЭХ ЦОГЦ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛНЭ.

№	ЗОРИЛТУУД	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.	Зорилт № 1 Хөтөлбөрийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн чанар, хүртээмжийн талаарх хөтөлбөрийн оролцогчдын нарийвчилсан судалгааг хичээлийн жил бүрээр гаргах түүнийг хэлэлцэх • Хөтөлбөрийг хөгжүүлэх эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх • Хөтөлбөрийн хороо, мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх • CDIO нийлмэл сургалтын хөтөлбөрийн стандартыг бүрэн хэрэгжүүлэх • Мэргэжлийн холбоод болон Хуулийн 	Судалгаанд суурилсан хөтөлбөр хөгжүүлэх бодлого хэрэгжинэ.

		байгууллагуудтай хамтран ажиллах шинэ түншлэлийн	
2.	Зорилт № 2 Оюутнууд болон төгсөгчид үзүүлэх төрөл бүрийн сургалтын үйлчилгээний хэлбэрүүдийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Оюутанд зориулсан соёл, хүмүүжлийн ажлыг шинэ түвшинд гаргах замаар оюуны бүх талын өргөн боловсролтой, ёс суртахууны өндөр хүмүүжилтэй мэргэжилтэн болон төгсөх нөхцлийг хангах • Орчин үеийн мэдээллийн технологийн дэвшилтэт хэлбэрүүдийг суралцах процесст өргөн ашиглах, оюутнуудыг E-орчноор хангах ажиллагааг өргөжүүлнэ. • CDIO суралцахуй болон сургах арга зүйн стандартуудыг бүрэн нэвтрүүлэх • Хосолсон болон идэвхитэй ёургалтын орчинг шат дараатайгаар бүрдүүлэх • Төгсөгчдийн давтан сургалтын хөтөлбөрийг сайжруулах, тогтмол зохион байгуулах • Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин нөхцөл болох анги танхим, дотуур байр, сурах бичиг гарын авлагын хүрэлцээ, техник хэрэгсэл, номын сан, суралцагсадад чиглэсэн мэдээллийн үйлчилгээ, амралтын танхим, цайны газар зэрэг чанартай сургалтанд шаардлагатай бүхий л 	Хөтөлбөрийн оролцогчдийг идэвхижүүлэх, хөтөлбөрийн чанар, стандартыг сайжруулах

		нөхцөл бололцоог бүрдүүлэх.	
3.	Зорилт № 3 Багшийн хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн удирдлага, сургалт судалгааны ажилтан, багш судлаач нарт үр дүнд суурилсан сургалт, судалгаа (outcome based)-ны арга зүйг эзэмшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулна. • CDIO ажлын орчин бүрдүүлэх • Багшийн хөгжлийн төвийг байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулах, бүтэц бүрэлдэхүүнийг олон улсын жишигт хүргэх • CDIO 9,10 дугаар стандартыг шат дараалалтайгаар хэрэгжүүлэх • Шихихутуг их сургуулийн хөгжлийн ерөнхий зураглалын 3 дугаар зорилтыг үе шаттай хэрэгжүүлнэ. • Багшийн ажлын үнэлгээг бодитой тогтоож, үр дүнгээр урамшуулах 	Хөтөлбөрийн оролцогчдийг идэвхижүүлэх, хөтөлбөрийн чанар, стандартыг сайжруулах
4.	Зорилт № 4 Төгсөгчдийн холбоотой хөтөлбөрийн хөгжлийн түвшинд хамтран ажиллах	Хамтран ажиллах санамж бичиг байгуулах замаар ажиллана.	Хөтөлбөрийг хөгжүүлэх олон талт ажил эрчимжих

ЗОРИЛГО ДӨРӨВ.**ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ОЛОН ХУВИЛБАРТ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОНО.**

№	ЗОРИЛТУУД	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.	Зорилт №1 Хөтөлбөрийг хөгжүүлэх төсвийн төлөвлөлтийг оновчтой болгох	<ul style="list-style-type: none">• Хөтөлбөрийг хөгжүүлэх төсвийг Их сургуулийн төсвөөс гадна сангийн болон бусад хэлбэрээс бүрдүүлнэ.• Хөтөлбөрийг хөгжүүлэхэд Их сургуулийн тухайн жилийн төсвийн тодорхой хувийг зарцуулах асуудлыг Удирдах зөвлөл, Хөтөлбөрийн хороотой зөвшилцөн шийдвэрлэнэ.• Хөтөлбөрийг хөгжүүлэх сангийн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.• Хөтөлбөр хөгжүүлэх сан нь бие даасан байх ба шилэн данстай байна.	Хөтөлбөрийн санхүүжилтийн оновчтой бөгөөд олон хувилбарт түвшинд шилжих боломжийг бүрдүүлнэ.
2.	Зорилт №2 Санхүүгийн зээл, тусламжийн төсөл хэрэгжүүлэх (хандивлагч иргэн, аж ахуйн нэгж, орон нутаг, засгийн газар, гадаад улс, олон улсын байгууллага)	Хөтөлбөрийн оролцогчдийн хөгжих боломжийг бий болгох зорилгоор хөтөлбөр хэрэгжүүлэгч нь хандивлагч иргэн, аж ахуйн нэгж, орон нутаг, засгийн газар, гадаад улс, олон улсын байгууллагатай хамтрах	Хөтөлбөрийн оролцогчдийн хөгжих олон талт бодлогыг дэмжинэ.

		ажиллах олон талт үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх	
3.	Зорилт №3 Гарааны бизнесийн үндэс суурийг тавьж, шийдвэрлэх асуудал, нөөц боломжийг судлах	Шихихутуг их сургуулийн хөгжлийн ерөнхий зураглалын 4 дүгээр бүлгийн агуулгыг үе шаттай хэрэгжүүлнэ.	Сургуулийн хөгжлийн шинэ шатны эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх зорилтыг хангах

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

Хөтөлбөрийн хороо стратеги төлөвлөгөөний хүрээнд бодлогын удирдлагаар ханган зохион байгуулах ба хөтөлбөрийн нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөтөлбөр хөгжлийн арга зүйн зөвөлгөөг өгч, биелэлтийг нь хариуцан зохион байгуулж ажиллана.

Нийт багш нар өөрийн төлөвлөгөөнд уг стратеги төлөвлөгөөнөөс тусган биелэлтийг нь дүгнүүлэн ажиллана.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад богино хугацааны ба шатлалын хяналт шинжилгээ хийж, шаардагдах зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Богино хугацааны хяналтыг жил бүрийн сургуулийн үйл ажиллагааны тайланд тусгана. Шатлалын хяналтыг дараах байдлаар хийж, хяналт шинжилгээ явуулан, хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж дүгнэлт шийдвэр гаргуулж байна.

I үе шат. Стратеги төлөвлөгөөний эхний үе шатны үнэлгээ хийх хугацаа: 2022 оны 6 дугаар сар

II үе шат. Стратеги төлөвлөгөөний 2 дахь үе шатны үнэлгээ хийх хугацаа: 2026 оны 6 дугаар сар

Хавсралт №1
CDIO стандартууд⁹

№	Стандартын нэр	Стандартын хамаарагдах чиглэлүүд
1.	Үзэл баримтлал	Нийлмэл сургалтын хөтөлбөр боловсруулах
2.	Суралцахуйн үр дүнгүүд	
3.	Нийлмэл сургалтын хөтөлбөр	
4.	Эрх зүйн удиртгал хичээл	Дадлага, төсөл ба сургалтын орчин
5.	Бүтээх, хэрэгжүүлэх дадлага	
6.	Эрх зүйчийн ажлын байр	
7.	Олон талт сургалтын арга, туршлага	Суралцахуй болон сургах арга зүй
8.	Идэвхитэй суралцахуй	
9.	Багш нарын CDIO чадвар	Багш нарын заах арга зүй болон мэргэжлийн мэдлэг чадварыг дээшлүүлэх
10.	Багш нарын заах арга зүйн чадамж	
11.	Сургалтын явцын үнэлгээ	Сургалтын хөтөлбөрийн үр дүн ба үнэлгээ
12.	Хөтөлбөрийн үнэлгээ	

⁹ Эрх зүйн хөтөлбөрийн онцлогтой холбогдуулан зарим агуулгыг тодотгов. Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам. CDIO Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж.,УБ, 2007.23 дахь тал